



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/137/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг Сайншанд
сум

2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: .70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn

Аудитор: Б.Отгон-Өлзий

Утас: 99844655 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	
2.11.	Шилэн дансны мэдээлэл	
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	
3	Менежментийн захидал	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ОЮУНСАЙХАН ТАНАА

2020.02.28 № 1-6/188
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг газрын дарга Ц.Оюунсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ний аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын эрхэм зорилго нь Газрыг геодези, зураг зүйд үндэслэн иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн баталгаатайгаар эзэмшүүлж, ашиглуулах ажлыг орон нутагт удирдан зохион байгуулж, гагцхүү Монгол улсын иргэнд газрын өмчлүүлэх, нутаг дэвсгэрийн барилгажилт, хот байгуулалт, архитектур төлөвлөлтийн бодлогыг аймаг, сум, суурин, хот тосгонд ерөнхий төлөвлөгөөг инженерийн эх үүсвэр, газар зохион байгуулах төлөвлөгөөнд тулгуурлан хэрэгжүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын болон төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалттай барилгын угсралт, их засварын ажилд хяналт тавих
- Газар, геодези зураг зүйн талаарх хууль тогтоомж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан

Тус Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр

2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 694,215.8 мянган төгрөгөөс тооцон 13,884.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 160,273.1 мянган төгрөгөөр буюу 23.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,500.0	2,000.0	500.0
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	24,586.5	37,552.3	13,052.7
Үндсэн хөрөнгө	967,279.2	1,180,774.7	213,495.4
Нийт хөрөнгө	680,850.9	841,124.1	160,273.1
Өр төлбөр	930.7		
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	680,850.9	841,124.1	160,273.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	680,850.9	841,124.1	160,273.1

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай зориулалтын материалын үлдэгдэл 199.2 мянган төгрөг, бичиг хэргийн материалын үлдэгдэл 3,159.9 мянган төгрөг, аж ахуйн материалын үлдэгдэл 14,195.7 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс, сэлбэг хэрэгслийн үлдэгдэл 2530.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд 1996 онд худалдаж авсан ашиглалтгүй 55 нэрийн 3,000.0 мянган төгрөгийн гарын авлага ном байна. Ашиглалтгүй хөрөнгийг акталж данснаас хасах зөвлөгөө өглөө.

Бараа материалын дансанд 2019 оны хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 18,303.9 мянган төгрөгийн гарын авлага, холбогдох үнэт цаас авсан ашиглагдаж байна.

ГЗБГЗЗГазраас үнэ төлбөргүй 11,718.6 мянган төгрөгийн хээрийн мониторингийн судалгааны тоног төхөөрөмж авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 213,495.4 мянган төгрөгөөр өссөн нь авто тээврийн хэрэгсэл 100,000.0 мянган төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 97,406.5 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Дээрх хөрөнгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос худалдан авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 841,124.1 мянган төгрөг болж 161,263.9 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын тайлант онд 45,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 82,433.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 83.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Газар олголтын үнэт цаасны орлого	28,001.9	28,001.9		100,0
Барилгын захиалагчийн хяналтын орлого	54, 431.9	368,180.9	313,749.0	5,7 дахин
Нийт дүн		396,182.9	313,749.0	

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 313,749.0 мянган төгрөгөөр давсан нь төсвийн төлөвлөлтийг бодиттой хийдэггүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 402,487.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 402,487.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 372,450.9 мянган төгрөгийг улсын, 15,018.2 орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлийг 401,550.3 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалин хөлсний зардал 285.5 мянган төгрөгөөр, ашиглалтын зардал 537.9 мянган төгрөгөөр, бусад зардлуудыг 1.3-43.6 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалж байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 396,182.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Хангамж бараа материалд 16,740.6 мянган төгрөг, нормативт зардалд 645.5 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 119,486.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 140,464,0 мянган төгрөг, томилолтын зардалд 6,111.2 мянган төгрөг, нийт 318,749.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 54,431.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 314,935.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 108.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 313,749.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1078.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 314,935.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 108.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 313,749.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Засвартай томилолтын хуудсаар болон томилолтын зам хоногийг илүү тооцож олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, УСНББОУС стандарттай нийцэхгүй үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Төсвийг төлөвлөхдөө барилга захиалагчийн хяналтын орлогыг өмнөх онуудын гүйцэтгэл, орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөтэй уялдуулж бодитой төлөвлөдөггүйгээс 2019 онд 313,749.0 мянган төгрөгөөр үндсэн үйл ажиллагааны орлого давж, аймгийн Засаг даргын 2019 оны 11 сарын 13-ны өдрийн 1/1950 дугаар албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүсэлт хүргүүлж, тус газрын 2019 оны 11 сарын 15-ны өдрийн 1/2817 дугаар албан бичгээр зөвшөөрөл авч зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалтуудыг зөрчиж үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 1078.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 санхүүгийн тайлангийн аудитаар барилга захиалагчийн хяналтын зардал 368,180.9 мянган төгрөгийн орлогыг нэмэлтийн дансанд төвлөрүүлж, үүнээс 54,431.9 мянган төгрөгийг төлөвлөн улсын төсөвт төвлөрүүлж, захиалагчийн

хяналтын зардлын үлдэгдлийг хөрөнгө бэлтгэж зарцуулсан байгаа тул дараагийн аудитаар тодруулж авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

Иймд 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар барилга захиалагчийн хяналтын зардлын орлогыг өмнөх 3-5 жилийн судалгаанд үндэслэн төвлөсөн эсэхийг авч үзэх шаардлагатай байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 132 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 0 мэдээллийг байршуулаагүй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 222.1 мянган төгрөгийн зөрчилд 222.1 төлбөрийн акт тогтоосноос 222.1 мянган төгрөгийг барагдуулсан байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Албан томилолтоор ажиллагсдад шаардлага хангахгүй анхан шатны баримтыг үндэслэн 1078.5 мянган төгрөгийн зочид буудлын мөнгө олгосон байна.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Анхан шатны баримтгүй зардлыг НББ-д тусгаж, үр дүнг буруу тайлагнах

3.1.3 Өгсөн зөвлөмж: Буудлын мөнгө төлсөн үйлчлүүлэгч байгууллагын кассын орлогын ордер буюу "Е" баримтыг үндэслэн томилолтын зардал олгож байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжтэй танилцсан, хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/Төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,086,502.76	39,552,273.36
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,500,000.00	2,000,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,500,000.00	2,000,000.00
3121	Төгрөг	1,500,000.00	2,000,000.00
31211	Төрийн сангийн харилцах	1,500,000.00	2,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,586,502.76	37,552,273.36
351	Түүхий эд материал	1,213,080.00	1,412,160.00
35110	Тусгай зориулалттай материал	1,213,080.00	1,412,160.00
354	Хангамжийн материал	23,373,422.76	36,140,113.36
35410	Бичиг хэргийн материал	9,413,261.78	12,573,180.38
35420	Аж ахуйн материал	9,371,159.00	23,566,931.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,530,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	2,059,001.98	01.98
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	654,764,466.24	801,571,785.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	654,764,466.24	801,571,785.92
392	Биет хөрөнгө	640,244,299.78	787,469,619.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	456,653,690.00	456,653,690.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-8,539,811.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,414,000.00	172,914,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,664,000.04	-36,247,333.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	319,112,608.81	416,518,078.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	-237,286,381.32	-275,936,232.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,600,995.00	53,190,895.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,211,612.67	-21,205,166.59
39214	Бусад үндсэн хөрөнгө	65,070,000.00	65,070,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-29,445,000.00	-34,948,500.00
393	Биет бус хөрөнгө	14,520,166.46	14,102,166.38
39301	Програм хангамж	2,940,000.00	2,940,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,907,833.54	-2,325,833.62
39303	Бусад биет бус хөрөнгө	13,488,000.00	13,488,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	680,850,969.00	841,124,059.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	930,742.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	930,742.00	00.00
413	Өглөг	930,742.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	930,742.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	679,920,227.00	841,124,059.28
51	Засгийн газрын хувь оролцоо	679,920,227.00	841,124,059.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	235,568,196.46	235,568,196.46
51101	Өмч: - төрийн	235,568,196.46	235,568,196.46
512	Хуримтлагдсан үр дүн	433,332,191.43	594,536,023.71
51210	Өмнөх үеийн үр дүн	433,332,191.43	433,332,191.43
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	161,203,832.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,019,839.11	11,019,839.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	680,850,969.00	841,124,059.28

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	497,909,049.00	855,419,648.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,011,813.00	48,305,846.00
120	Нийтлэг татварын бус орлого	30,011,813.00	48,305,846.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,511,813.00	46,305,846.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,511,813.00	28,001,946.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	18,303,900.00
120009	Бусад орлого	1,500,000.00	2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	135,141,436.00	419,644,702.40
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	332,755,800.00	387,469,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	123,720,496.00	392,907,902.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	370,000.00	24,726,980.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	122,850,496.00	368,180,922.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	15,018,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	15,018,200.00
1330	Төсвийн захирагчдаас	11,420,940.00	11,718,600.00
133003	Хөрөнгийн	11,420,940.00	11,718,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	533,182,487.78	694,215,816.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	533,182,487.78	694,215,816.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	464,708,845.78	606,008,275.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	243,279,917.00	299,870,233.30
210101	Үндсэн цалин	189,862,977.00	217,205,333.30
210102	Нэмэгдэл	34,948,900.00	63,531,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,740,180.00	8,408,600.00
210104	Урамшуулал	00.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,727,860.00	10,724,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,820,396.00	37,290,195.00
210201	Тэтгэврийн даатгал	18,586,019.00	25,793,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,412,800.00	3,014,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,956,918.00	2,509,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	439,009.00	601,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,425,650.00	5,371,495.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,731,655.00	13,084,350.00
210301	Гэрэл, цахилгаан	2,313,511.00	2,274,221.00
210302	Түлш, халаалт	6,515,362.00	8,400,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,902,782.00	2,410,129.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,064,616.00	38,735,733.40
210401	Бичиг хэрэг	12,684,707.00	15,802,691.40
210402	Тээвэр, шатахуун	22,503,000.00	21,488,918.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	331,900.00	349,300.00

**Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	104,316.00	130,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,927,333.00	964,124.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	13,400.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	1,499,960.00	00.00
2105	Нормативт зардал	552,134.00	450,005.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	552,134.00	450,005.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,485,490.00	55,421,676.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,485,490.00	9,983,900.00
210604	Урсгал засвар	00.00	45,437,776.00
2107	Томилолт, зочны зардал	4,657,700.00	8,572,500.00
210702	Дотоод албан томилолт	4,657,700.00	8,572,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,023,300.00	24,772,825.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,480,000.00	24,084,689.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	118,800.00	118,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	424,500.00	425,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	121,636.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,093,637.78	127,810,757.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,015,681.00	60,946,207.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	796,000.00	176,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	86,281,956.78	66,688,050.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,473,642.00	88,207,541.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,826,400.00	4,728,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,326,400.00	2,228,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	2,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,456,043.00	30,760,545.10
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	398,950.70
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	00.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,456,043.00	30,361,594.40
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	643,750.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	643,750.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,191,199.00	52,075,246.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,191,199.00	52,075,246.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-35,273,438.78</u>	<u>161,203,832.28</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	332,745,744.10	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	332,745,744.10	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-332,745,744.10	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-368,019,182.88</u>	<u>161,203,832.28</u>

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>486,488,109.00</u>	<u>825,397,148.40</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,011,813.00	30,001,946.00
120	Нийтлэг татварын бус орлого	30,011,813.00	30,001,946.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,511,813.00	28,001,946.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,511,813.00	28,001,946.00
120009	Бусад орлого	1,500,000.00	2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	456,476,296.00	795,395,202.40
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	332,755,800.00	387,469,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	123,720,496.00	392,907,902.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	370,000.00	24,726,980.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	122,850,496.00	368,180,922.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	15,018,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	15,018,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>437,071,364.00</u>	<u>627,401,778.40</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437,071,364.00	627,401,778.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	368,597,722.00	539,194,237.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	241,895,535.00	300,275,070.30
210101	Үндсэн цалин	182,789,735.00	217,610,170.30
210102	Нэмэгдэл	38,782,400.00	63,531,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,470,500.00	8,408,600.00
210104	Урамшуулал	00.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,852,900.00	10,724,600.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,903,400.00	37,816,100.00
210201	Тэтгэврийн даатгал	19,233,400.00	25,793,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,412,800.00	3,005,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,918,900.00	2,404,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	500,100.00	601,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,838,200.00	6,011,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,857,655.00	13,084,350.00
210301	Гэрэл, цахилгаан	2,313,511.00	2,274,221.00
210302	Түлш, халаалт	6,515,362.00	8,400,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,028,782.00	2,410,129.00

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	26,710,793.00	24,498,074.00
210401	Бичиг хэрэг	4,429,600.00	3,359,000.00
210402	Тээвэр, шатахуун	20,481,000.00	19,332,918.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	357,700.00	357,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	104,316.00	130,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,338,177.00	1,317,756.00
2105	Нормативт зардал	388,657.00	997,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	388,657.00	997,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,598,900.00	54,774,714.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	510,000.00	8,685,600.00
210602	Тавилга	420,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,668,900.00	46,089,114.00
2107	Томилолт, зочны зардал	4,657,700.00	8,572,500.00
210702	Дотоод албан томилолт	4,657,700.00	8,572,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,023,300.00	30,470,825.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,480,000.00	29,782,689.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	118,800.00	118,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	424,500.00	425,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	121,636.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,561,782.00	68,704,754.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,625,457.00	68,330,954.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	936,325.00	373,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,473,642.00	88,207,541.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,826,400.00	4,728,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,326,400.00	2,228,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	2,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,456,043.00	30,760,545.10
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	398,950.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,456,043.00	30,361,594.40
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	643,750.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	643,750.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,191,199.00	52,075,246.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,191,199.00	52,075,246.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>49,416,745.00</u>	<u>197,995,370.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	47,916,745.00	197,495,370.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,916,745.00	197,495,370.00
2200	Дотоод эх үүсвэрээр	47,916,745.00	197,495,370.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	47,916,745.00	197,495,370.00

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-47,916,745.00</u>	<u>-197,495,370.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,500,000.00	500,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	1,500,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,500,000.00	2,000,000.00

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,568,196.46	11,019,839.11	433,332,191.43	679,920,227.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,568,196.46	11,019,839.11	433,332,191.43	679,920,227.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	235,568,196.46	11,019,839.11	433,332,191.43	679,920,227.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	161,203,832.28	161,203,832.28
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,568,196.46	11,019,839.11	594,536,023.71	841,124,059.28

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	332,670,100.00	332,242,197.00	402,487,300.00	401,550,399.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	332,670,100.00	332,242,197.00	402,487,300.00	401,550,399.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,430,100.00	330,015,797.00	400,247,300.00	399,322,399.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	241,903,900.00	241,895,535.00	300,560,600.00	300,275,070.30
210101	Үндсэн цалин	182,798,100.00	182,789,735.00	219,799,700.00	217,610,170.30
210102	Нэмэгдэл	38,844,300.00	38,782,400.00	61,627,700.00	63,531,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,408,600.00	8,470,500.00	8,408,600.00	8,408,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,852,900.00	11,852,900.00	10,724,600.00	10,724,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,909,600.00	28,903,400.00	37,510,100.00	37,570,100.00
210201	Тэтгэврийн даатгал	19,233,400.00	19,233,400.00	25,548,900.00	25,547,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,412,800.00	2,412,800.00	3,004,500.00	3,005,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,941,400.00	1,918,900.00	2,403,400.00	2,404,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	483,800.00	500,100.00	601,100.00	601,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,838,200.00	4,838,200.00	6,012,200.00	6,011,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,973,300.00	10,857,655.00	13,622,300.00	13,084,350.00
210301	Гэрэл, цахилгаан	2,329,400.00	2,313,511.00	2,629,400.00	2,274,221.00
210302	Түлш, халаалт	6,547,900.00	6,515,362.00	8,426,800.00	8,400,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,096,000.00	2,028,782.00	2,566,100.00	2,410,129.00
210304	Байрны түрээс	00.00	00.00	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,935,800.00	8,895,693.00	7,785,800.00	7,757,456.00
210401	Бичиг хэрэг	2,295,000.00	2,289,500.00	1,145,500.00	1,145,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,806,300.00	4,806,000.00	4,805,800.00	4,805,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	357,700.00	357,700.00	357,700.00	357,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	130,700.00	104,316.00	130,700.00	130,700.00

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,346,100.00	1,338,177.00	1,346,100.00	1,317,756.00
2105	Нормативт зардал	396,000.00	388,657.00	396,000.00	352,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	388,657.00	396,000.00	352,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,394,900.00	1,358,900.00	1,395,900.00	1,395,900.00
210604	Урсгал засвар	1,394,900.00	1,358,900.00	1,395,900.00	1,395,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,462,200.00	1,462,200.00	2,462,200.00	2,461,300.00
210702	Дотоод албан томилолт	1,462,200.00	1,462,200.00	2,462,200.00	2,462,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	715,400.00	543,300.00	715,400.00	688,136.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	118,800.00	118,800.00	118,800.00	118,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	425,700.00	424,500.00	425,700.00	425,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	00.00	148,500.00	121,636.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,400.00	00.00	22,400.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35739000.00	35710457.00	35739000.00	35737737.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,739,000.00	35,710,457.00	35,739,000.00	35,737,737.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2240000.00	2226400.00	2240000.00	2228000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,240,000.00	2,226,400.00	2,240,000.00	2,228,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,240,000.00	2,226,400.00	2,240,000.00	2,228,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	402,487,300.00	402,487,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	387,469,100.00	387,469,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	332,670,100.00	332,755,800.00	387,469,100.00	387,469,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	15,018,200.00	15,018,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	15,018,200.00	15,018,200.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	34.00	34.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	28.00	28.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	05.00	05.00

4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН			342,064,738,00	338367208.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ			342064738,00	338367208.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ			341,064,738	337,367208
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл			246,000	246,000
210201	Тэтгэврийн даатгал			246,000	246,000
2104	Хангамж, бараа материалын зардал			18,882,820.00	16,471,618.00
210401	Бичиг хэрэг			3,431,510.00	2,213,500.00
210402	Тээвэр, шатахуун			15,451,310.00	14,527,118.00
2105	Нормативт зардал			645,500.00	645,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл			645,500.00	645,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал			119,526,134.00	119,486,184.00
	Багаж техник хэрэгсэл			68,043,020.00	68,003,070.00
210604	Урсгал засвар			44,693,214.00	44,693,214.00
2107	Томилолт, зочны зардал			7,196,499.00	6,111,200.00
210702	Дотоод албан томиллолт			7,196,499.00	6,111,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж			53,853,689.00	53,673,689.00
210802	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж			53,853,689.00	53,673,689.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал			140,714,096.00	140,464,017.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			140,340,296.00	140,090,217.00
				373,800.00	373,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ			1,000,000.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг			1000,000,00	1,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			396,605,432.00	392,907,902.40
131007	Нэмэлт санхүүжилтийн орлого			396,605,432.00	392,907,902.40
1320	Дээд шатны төсөв захирагчаас			28,424,510.00	24,726,980.00
132001	Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого			368,180,922.00	367,180,922.40